



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2021. 04. 23 № 18

Асуулга тавих тухай

Монгол Улсад Коронавируст цар тахал өдрөөс өдөрт мянга мянгаар нэмэгдэж, нас баралт 60 гарсан байна. Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв ачааллаа дийлэхгүй, эмч, эмнэлгийн ажилтнууд өдөр, шөнөгүй ажиллаж байгаа ч сүүлийн үед тэдний холбогдсон гэх асуудлууд ар араасаа гарсаар байгаа нь нийгмийг цочирдуулж, талцуулаад байна.

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн нэр бүхий эмч, ажилтнууд 80 мянган төгрөгөөр шинжилгээний хариуг солих, бусдын өмнөөс шинжилгээ авах зэрэг зөрчил гаргасан талаар мэдээлсэн.

Түүнчлэн Эрүүгийн Цагдаагийн газар болон Тагнуулын байгууллагаас Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвд хийсэн хяналт, шалгалтаар тусгай үүргийн нислэгээр явсан 6000 орчим иргэн шинжилгээний төлбөр төлсөн бөгөөд хуримтлагдах ёстой 900 орчим сая төгрөгөөс 400 гаруй сая төгрөг Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн дансанд хуримтлагдсан талаар болон тус төвийн эмч, ажилтан болох С гэгч 21260, М гэгч 18328 удаа, Н гэгч нь 8483 удаа тус тус эрүүл.гэрэгэ.мн /eruul.gerege.mn/ системээр нэвтэрч, иргэдийн шинжилгээний хариуг засварлаж хувьдаа их хэмжээний хөрөнгө завшсан гэх эмч, эмнэлгийн ажилтнуудыг буруутгасан мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаад байна.

Цар тахлын нөхцөл байдал хүнд байгаа энэ цаг үед халдварт өвчинтэй тэмцэх тэргүүн эгнээнд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнууд Коронавирусийн халдварыг тараасан мэт ойлголт төрөхүйц мэдээлэлтэй холбогдуулж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулж дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна.


2020000163

1. Коронавирусийн шинжилгээ авах, хариу гарах үйл явцад ХӨСҮТ-ийн эмч, ажилтнуудын оролцоо ямар байгаа, эрүүл.гэрэгэ.мн /eruul.gerege.mn/ сайтад шинжилгээний хариуг хэрхэн шивдэг талаар;
2. Тагнуулын Ерөнхий газар, Эрүүгийн Цагдаагийн газар ХӨСҮТ-д хамтарсан шалгалт хэзээ оруулсан, хяналт шалгалтын албан ёсны дүгнэлт гарсан эсэх;
3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээд байгаа ХӨСҮТ-ийн эмч, ажилтнууд олон мянган иргэний шинжилгээний хариу засварласан байж болзошгүй асуудлыг холбогдох хуулийн байгууллага шалгаж байгаа эсэх;
4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр нь дурдагдаж байгаа эмч, ажилтнууд ажлаа хийж байгаа эсэх, шинжилгээний хариу завсарлагдсан гэх тоо баримтын эх сурвалжийн талаар, энэ тоо баримт бодитой байх боломжтой эсэх талаар үндэслэл бүхий мэдээллийг;
5. Цар тахалтай тэмцэн хүнд нөхцөлд, илүү цагаар ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн илүү цагийн хөлс, урамшуулал, нөхөн олговрыг бүрэн олгосон эсэх, нийт хэдэн ажилтанд ямар хугацаанд хэдэн төгрөг олгосон талаар;
6. Цар тахлын голомтод дайчилгаагаар ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу цалин хөлсийг нь 3 дахин нэмэгдүүлж олгох ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгох ажлыг хэрэгжүүлэх боломжтой эсэх, цар тахлын голомтод дайчлагдаж ажиллаж байгаа эрүүл мэндийн нийт хэдэн ажилтан байгаа, тэдгээрт хэдэн төгрөг олгох талаар тоо судалгаа гаргасан эсэх, хэрэв ийм тооцоо судалгаа хийгдсэн бол дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлэх;
7. Эрүүл мэндийн салбарыг улс төржилтөөс ангид байлгах талаар хийж, хэрэгжүүлж байгаа бодлогын ажлынхаа талаарх мэдээллүүдийг ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3, 39.4-т заасны дагуу ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.ТУВААН



2020000163